



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.26 № 01/11

Улсын төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу БНСУ дахь Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 11,927,881.06 төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д: "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д: ".....аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих", Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1-д: "төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсвэл төвлөрүүлээгүй зөрчилд төрийн аудитын байгууллага акт тавина" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дээр дурдсан 11,927,881.06 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 900000601 тоот дансанд 2014 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлж, улсын төсвийн орлого болгох,

2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 06 дугаар сарын 01-ны дотор YAГ-т ирүүлэхийг БНСУ дахь Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Ц.Өнөрзаяа, Ерөнхий нягтлан бодогч Б.Ганчимэг нарт хариуцуулав.

**АКТЫГ**



Үндэсний аудитын газрын  
Аудитор *I. Туяа*



БНСУ дахь НХУТ-ийн дарга  
Ц.Өнөрзаяа  
Ерөнхий нягтлан бодогч  
Б.Ганчимэг